



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 01

Даланзадгад

Г Шинэ коронавирусын халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.5-ын “в” дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай” 358 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Томуугийн цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай” А/438 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэр, 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Аймгийн онцгой комиссын 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

1.1. Хилийн боомтоор зорчигч тээврийн хэрэгслээр болон явганаар зорчих иргэдийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах саналыг Улсын онцгой комисс, Засгийн газарт хүргүүлэх.

1.2. Эрүүл мэндийн газар болон Мэргэжлийн хяналтын газарт нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зардал шийдвэрлэх.

2. Сумдын Засаг дарга нарт:

2.1. Аймгийн хэмжээнд урлаг соёл, спортын арга хэмжээ, хурал зөвлөгөөн, найр наадам, уралдаан тэмцээн, жагсаал, цуглаан, аялал, зугаалга, үзэсгэлэн худалдаа, дугуйлан, секц, компьютер тоглоомын газар, мөсөн гулгуур, фитнес, спорт заалны үйл ажиллагаа, шөнийн клуб, бүжиг, караоке зэрэг олон хүн цуглуулсан үйлчилгээ, арга хэмжээнүүдийг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хориглох.

2.

2.2. Сум орон нутгийн хэмжээнд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын болон хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг шийдвэрлэн ажиллах.

2.3. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, эрхлэгч наарт бэлэн байдлыг хангаж ард иргэд, албан байгууллага, хамт олон, ажилчдаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж, нэгдсэн мэдээлэл, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах, үүрэг чиглэлийг өгөх, хэрэгжилтийг хангуулах.

2.4. Аж ахуйн нэгж, албан байгууллагууд, худалдаа үйлчилгээний газрууд цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, халдвартгүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших.

2.5. Баг, хорооны Засаг дарга нарыг харьяа багийн иргэдэд мэдээлэл сургалт, сурталчилгаа хүргэх, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хариуцлагатай ажиллуулах.

3. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, эрхлэгч наарт:

3.1. Мэргэжлийн байгууллагууд хил орчмын хяналт шалгалтыг сайжруулах, хилийн нэвтрэх цэг дээрх зорчигчдын эрүүл мэндийг хянах, үнэлэх, тандалт судалгаа явуулах.

3.2. Байгууллагын ажилчид болон үйлчлүүлэгч нарыг амны хаалт /маск/ бусад хамгаалах хувцсаар хангах.

3.3. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтныхаа биеийн эрүүл мэнд дархлааг дэмжих, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, халуун хэмжигчийг байршуулах.

3.4. Байгууллага бүр ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, гар угаах орчин нөхцөлөө сайжруулах, халдвартгүйтгэх бодис, уусмалаар хангах.

3.5. Байгууллага бүр өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээ, халдвартгүйтгэл, агааржуулалтыг өдөр бүр хийж хэвших.

3.6. Нийтийн тээврийн газрууд халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөө бэлтгэх, халуун хэмжигч байрлуулах, сэжигтэй тохиолдлыг Эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэх ба тээвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх.

3.7. Байгууллагын ажилчиддаа хүргэх мэдээллийг эрүүл мэндийн байгууллагаас авч, үнэн зөв мэдээллийг тогтмол шуурхай хүргэх.

3.8. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0-5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 5 хүртэлх хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагч наарт цалинтай чөлөө олгох, өрх толгойлсон эцэг эх, асран хамгаалагч нарыг богиносгосон цагаар ажиллуулахыг ажил олгогч наарт зөвлөсүгэй.

3.

3.9.Холбогдох мэргэжлийн байгууллагууд үзвэр, үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагдаж буй эсэхэд хяналт тавих, эргүүл хийх.

3.10.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд өвчлөлийн тархалт, цаг үеийн мэдээлэл, зөвлөгөө зөвлөмжийг Эрүүл мэндийн газраас авч олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд тогтмол хүргэх.

4.Эрүүл мэндийн байгууллагад:

4.1.Эм эмнэлгийн хэрэгсэл, нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эмч мэргэжилтний хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх.

4.2.Зөвхөн аймгийн Эрүүл мэндийн газраас өвчний талаар үнэн бодит мэдээллээр иргэдийг хангаж, иргэдэд хүргэх мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимжүүлэн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах.

4.3.Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед сум өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх.

4.4.Түргэн тусламжийн үйлчилгээний унаа, эмч нарыг нэмэгдүүлэх, сум өрхийн эрүүл мэндийн төвийн болон амбулаторийн эмч нарыг шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллуулах.

4.5.Эрүүл мэндийн байгууллагын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлэх, эмч, мэргэжилтнүүд халдварт хамгааллын дэглэм мөрдөж ажиллах.

4.6.Эмийн сангүүд эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тасалдуулахгүй байх, хандив тусламж үзүүлж, хамтарч ажиллах, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, үнийг үндэслэлгүйгээр нэмэхгүй байх.

4.7.Хээрийн эмнэлэг дэлгэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, төлөвлөх.

5.Уул уурхай компаниудад:

5.1.Нүүрс, баяжмалын тээврийн жолооч нарын эрүүл мэндийг тогтмол хянах, үнэлэх, урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжөөр хангах.

5.2.Ажилчдын кэмп, амрах байранд цэвэрлэгээ үйлчилгээ, халдвартгүйтгэл болон агааржуулалтыг өдөр бүр хийж хэвших.

5.3.Халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөө бэлтгэх, халуун хэмжигч болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг байрлуулах, сэжигтэй тохиолдлыг Эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэх ба тээвэрлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх.

5.4.Дотоод эрүүл мэндийн алба, нэгжийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлэх, эмч мэргэжилтэнг мэргэшүүлэх.

5.5.Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтныхаа биеийн эрүүл мэнд дархлааг дэмжих арга хэмжээг зохион байгуулах.

6.Нийт иргэдэд уриалах нь:

6.1.Томуу, томуу төст өвчинөөс болон шинэ коронавирусын халдвартын болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон гэр бүлээ урьдчилан сэргийлэх зорилгоор дулаан хувцаслах, амны хаалт тогтмол зүүж хэвших, гарсаа тогтмол угаах, шаардлагагүй тохиолдолд олон нийтийн газраар зорчихгүй байх, биеийн эсэргүүцэл сайжруулах амин дэмээр баялаг хоол хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх.

6.2.Сургууль, цэцэрлэгийн настын хүүхдийн хараа хяналтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, хүүхдийг дагуулж олон нийтийн газраар явахгүй байх, өвчлөл гарсан улс оронд аль болох зорчихгүй байх.

7.Албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар /Л.Баярсайхан/, Цагдаагийн газар /Г.Наранбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтулга/, Эрүүл мэндийн газар /Ц.Өнөржаргал/-т тус тус үүрэг болгосугай.

8.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, өвчний тархалтын байдал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн 7 хоног бүр Засаг даргад тайлagnаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Ү.Энхцацral/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.НАРАНБААТАР

